



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ²¹ он ¹¹ дугаар
сарын ¹² ны өдөр

Дугаар ^{ХТ/2710}

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА


Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх хөдөлмөрийн зах зээлийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ¹² хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



 Ц.НЯМДОРЖ

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал

Монгол Улс 2020 оны 1 дүгээр сараас өнөөдрийг хүртэл хугацаанд дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эсрэг тэмцэж, эдийн засаг, нийгмийн хүнд нөхцөл байдал, сорилтуудтай тулгарч байна.

Цар тахлын улмаас дэлхий нийтээр 2020 онд 114.0 сая ажлын байр баталгаагүй байдалд орсон бөгөөд үүнээс 33.0 сая ажлын байр цомхотголд орж, 81.0 сая ажлын байр идэвхгүй болжээ. Америк тивд ажлын байрны алдагдлын түвшин хамгийн их байсан бол Европ болон Төв Азид ажлын цагийг багасгах замаар ажлын байрны алдагдлыг харьцангуй бага түвшинд барьсан байна. Эмэгтэйчүүдийн ажлын байрны алдагдал эрэгтэйчүүдийнхээс 5.0 хувиар илүү, залуучуудын ажлын байрны алдагдал ахимаг насныхнаас 8.7 хувиар илүү байсан байна¹.

Улс орнууд ажлын байрыг хадгалж, хамгаалах хүрээнд ажлын цагийг багасгах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажиллаагүй цагийн олговор болон богино хугацааны нөхөн олговор олгох, ажиллах хүчний дахин хуваарилалт хийх, мөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлсэн байна.

Харин манай улсын хувьд Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээгээр ажилгүйдлийн түвшин 2020 оны I, II улиралд 6.6 хувь, III улиралд 7.3 хувь, IV улиралд 7.6 хувь байсан бол 2021 оны I улиралд 8.8 хувь, II улиралд 8.4 хувь болжээ.

2020 оны эхэн ба дунд үед ажилгүйдлийн түвшин бага байсан нь Засгийн газраас ажлын байрыг хадгалах, иргэдийн орлогыг бууруулахгүй байх шат дараатай арга хэмжээг шуурхай хэрэгжүүлсний үр дүн гэж үзэж болохоор байна. Харин оны сүүлээр ажилгүйдлийн түвшин өссөн нь бүх нийтийн хөл хорио тогтоож, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой байна.

Хөдөлмөрийн зах зээлийн өөр нэг чухал үзүүлэлт болох ажиллагчдын тоо 2018 онд 1.3 сая, 2019 онд 1.1 сая, 2020 онд 1.2 сая байсан бол 2021 оны I улиралд 1.05 сая, харин 2021 оны II улиралд 1.1 сая болж, өмнөх улирлаас 50.8 орчим мянгаар өссөн байна.

Монгол Улсын ажиллах хүчний оролцооны түвшин 2021 оны II улиралд 56.8 хувь байна. Энэ үзүүлэлт 2018 онд 61.0 хувь, 2019 онд 60.5 хувь, 2020 онд 58.8 хувь тус тус байсан нь сүүлийн жилүүдэд ажиллах хүчний оролцооны түвшин буурч байгааг илтгэж байна. Ялангуяа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 2021 оны II улиралд 49 хувь байгаа нь эрэгтэйчүүдээс 16.7 хувиар бага үзүүлэлт юм.

¹ Эх сурвалж: www.ilo.org

Монгол Улсад 2021 оны II улирлын байдлаар ажиллах хүчнээс гадуурх нийт 917.0 мянган хүн ам байгаагийн 63.2 хувь буюу 579.5 мянга нь эмэгтэйчүүд байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын дийлэнх хувь нь эмэгтэйчүүд байгаа шалтгааныг авч үзвэл эмэгтэйчүүдийн 37.6 хувь нь тэтгэвэрт гарсан, 24.1 хувь нь суралцдаг, 17.9 хувь нь хүүхэд асарч байгаа, 3.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 2.9 хувь нь өвчтөн, өндөр настан асарч байгаа зэрэг шалтгаантай байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд болон хөдөлмөрийн хувийн биржүүд 2020 онд нийт 58.0 мянган ажлын байрны захиалгыг хүлээн авч, 33.0 мянган хүнийг зуучлан оруулсан. Энэ нь ажлын байрны захиалгын тоо өмнөх оноос 13.1 мянган хүнээр, ажилд зуучлан оруулсан хүний тоо 11.0 мянган хүнээр тус тус буурсан байна. Түүнчлэн нийт 51.5 мянган хүнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх оноос 45.1 мянган хүнээр буурсан үзүүлэлт юм.

Харин 2021 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 32.6 мянган ажлын байрны захиалга хүлээн авч, 17.6 мянган хүнийг ажилд зуучлаад байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 30.2 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 17.1 хувь нь барилга, 7.7 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамж, 7.0 хувь нь уул уурхай, 6.1 хувь нь боловсруулах үйлдвэрийн салбарт ирсэн байна.

Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс буурсны дийлэнх хэсэг нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, түүнчлэн хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт гарсан бууралтаас шалтгаалсан байна.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтийн 2020 оны статистик тоон мэдээллээс үзэхэд албан салбарт ажиллагчдын хувьд цар тахлын нөлөөлөл харьцангуй бага туссан. Энэ нь цар тахал дэлхийн хэмжээнд бүртгэгдсэнээс хойш эхний 10 сарын хугацаанд Монгол Улс цар тахлыг дотооддоо алдаагүй, мөн Монгол Улсын Засгийн газраас ажлын байрыг хадгалах, хамгаалах чиглэлээр тодорхой шат дараатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсний үр дүн гэж үзэж болохоор байна.

Засгийн газраас хөтөлбөр эрхлэлтийг дэмжих хүрээнд хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг боловсронгуй болгон шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү шинэчлэлийн гол агуулга нь ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангах, коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгч иргэдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжихэд чиглэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд 2021 онд нийт 24.5 тэрбум төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөр, арга хэмжээнд энэ оны эхний 9 сарын байдлаар нийт 14.9 мянган хүнийг хамруулж, 8663 байнгын, түр болон цагийн ажлын байр бий болгосон. Эдгээр арга хэмжээ нь ажилгүй болон ажил хайгч иргэд, ажил олоход хүндрэлтэй иргэд, өдрийн орлогоор амьдрал, ахуйгаа зохицуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус эдийн засгийн салбарт ажиллагчид болон бусад зорилтот бүлгийн иргэн, аж ахуйн нэгжүүдийн хувьд чухал дэмжлэг болсон.

Мөн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-д туссан ажлын байрыг дэмжих зорилтын хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 2.0 их наяд төгрөгийн ажлын байрыг дэмжих зээлийг банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгож байна. 2021 оны эхний 9 сарын байдлаар нийт 1.8 их наяд орчим төгрөгийн зээлийг 24.0 мянган иргэн, аж ахуйн нэгжид олгосноор нийт 100.1 мянган ажлыг байрыг хадгалсан.

Үүний зэрэгцээ цар тахлын үед төрөөс аж ахуйн нэгж, даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэлээс болон торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн нь ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг болж, ажлын байраа хадгалах, мөн иргэдийн хувьд шимтгэл төлсөн хугацаа тасрахгүй байх боломжийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Энэхүү арга хэмжээгээр 2020-2021 онд 38.9 мянган аж ахуйн нэгж, байгууллага шимтгэлийн чөлөөлөлтөд хамрагдаж, нийт 579.9 мянган даатгуулагчийг 873.8 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлж, ажилгүйдлийн даатгалын сангаас 80.9 мянган даатгуулагчдад 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэг, нийт 917.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүллээ. Мөн 27.9 мянга орчим аж ахуйн нэгж, байгууллага 43.7 тэрбум төгрөгийн торгууль, алдангиас чөлөөлөгдсөн байна.

Монгол Улсын Засгийн газраас хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг төрөөс хариуцах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн нь шууд болон шууд бус байдлаар нийгэм, эдийн засагт зэрэг нөлөөг бий болгож, ажлын байрыг хадгалах, хамгаалах, иргэдийн орлогыг огцом бууруулахгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил болсон.

Түүнчлэн хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрийн харилцааны өнөөгийн байдал, олон улсын хэм хэмжээ, чиг хандлагад нийцүүлэн хөдөлмөрийн харилцааны хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлууллаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хуулийн хамрах хүрээг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн гурвалсан харилцаа, бүтэн бус цагаар ажиллах, зайнаас ажиллах, хувь хүн хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, уртын ээлжээр ажиллах болон ажилтны цалин хөлсийг ур чадвар, мэргэшлийн зэрэгтэй нь уялдуулан олгох зэрэг харилцааг тусгаж өгсөн.

Халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын зорилтын хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээ авдаг хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай

иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжид заасан зарим арга хэмжээ, үйлчилгээнд заавал хамрагдах нөхцөлтэйгөөр халамжийн зарим үйлчилгээг үзүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан ажиллаж байна. Тухайлбал, 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар нийгмийн халамжийн хүнсний эрхийн бичиг авдаг 4462 иргэдийг ургац хураалтын ажилд хамруулаад байна. Мөн “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-д өөрчлөлт оруулснаар нийт 7 аймгийн 8 сум, 3 баг, 1 дүүргийн 2 хороо хүнсний эрхийн бичигт хамрагддаг өрхгүй болсон бөгөөд нийт 5766 өрхийн 33660 иргэн хүнсний эрхийн бичгээс хасагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон холбогдох бусад яамд, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийг боловсруулж Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор батлуулсан. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн хүрээнд 2021 онд 18-34 насны нийт 5000 залуучуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэх багц сургалтыг зохион байгуулж, ажлын байранд дадлагажуулан ажилд зуучлах ажлыг амжилттай зохион байгуулж байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх вакуумжуулсан 14 хоногийн сургалтын эхний 6 ээлжийг энэ оны 9 дүгээр сараас эхлэн зохион байгуулж, нийт 2136 залуучуудыг хамруулсан бөгөөд 10 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 959 оролцогч ажил олгогч нартай гэрээ байгуулж, 194 оролцогч байнгын ажлын байртай болоод байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бус нутгийн эдийн засгийн бүтэц, онцлог, хөгжлийн чиг хандлагад тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлэх, салбар дундын дадлагын бааз байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхоныг бүтээн байгуулах ажлын урьдчилсан зураг төсөл, суурь судалгааг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Салбарын цахим шинэчлэлийн хүрээнд нийгмийн халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийн цахим мэдээллийн сангуудын уялдааг бүрэн хангаж, Цахим мэдээллийн нэгдсэн сан бүхий тогтолцоо бий болгохоор ажиллаж байгаа бөгөөд энэ чиглэлээр хийгдсэн ажлуудыг дурдвал:

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг оновчтой удирдах болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, зохицуулалтын шийдвэр гаргахад статистик мэдээлэлд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй, ирээдүйд бий болох үр дүнгийн тооцоо, судалгаатай байх боломжийг хангахад зориулсан “Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ыг боловсруулж, туршилтаар ажиллуулж эхэллээ. Цахим шилжилтийн эрин үед их өгөгдөл ашиглан аливаа бодлого, шийдвэрийг үндэслэл, тооцоотой, хувилбартай гаргах боломжийг энэхүү цахим мэдээллийн сан болон динамик загвар бий болгох ач холбогдолтой юм;
- Дэлхийн банкны санхүүжилтээр Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем “E-JOB” платформыг шинэчлэн хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Энэхүү нэгдсэн системийн үйл ажиллагааг 2022 оны 8 дугаар сард бүрэн ашиглалтад оруулах бөгөөд ингэснээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн төрийн болон хувийн байгууллагын бүхий л үйлчилгээ, арга хэмжээ, бүртгэл, мэдээлэл нэг дор төвлөрч, үйлчилгээ, хөтөлбөр, арга хэмжээний үр дүн, санхүүжилт, тайлан мэдээнд хурдан шуурхай дүгнэлт хийх, шийдвэр гаргах нөхцөл бүрдэнэ;

- Энэ оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хөдөлмөр эрхлэлтийн цахим үйлчилгээг www.ejob.gov.mn вэбсайтаар дамжуулан ажил хайгч иргэн, ажилтан хайж байгаа ажил олгогчид шинээр үзүүлж эхэлсэн. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас үүдэн ажилгүй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг биечлэн үзүүлж, ажилд зуучлахад хүндрэлтэй болж байгаа энэ цаг үед хөдөлмөр эрхлэлтийн төрийн байгууллага болон хөдөлмөрийн хувийн биржүүд уг цахим системээр дамжуулан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хурдан шуурхай, цаг алдахгүй хүргэж, хөдөлмөр зуучлалын ажлыг зохион байгуулах боломжтой болсон;
- Ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний нэгдсэн мэдээллийн санг www.ezuvshuurul.mn вэбсайтад төвлөрүүлж, ажиллах хүч гадаадад илгээх болон гадаадаас ажиллах хүч авах гэсэн цахим системийг ажиллуулж эхэллээ. Уг мэдээллийн сангийн гадаадаас ажиллах хүч авах үйлчилгээний цахим системийг бүрэн ашиглалтад оруулж, сургалт, сурталчилгааны ажлыг хийж эхэлснээс гадна Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг туршиж байна.

Гурав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Монгол Улсын Засгийн газраас урт болон дунд хугацааны бодлогын зорилго, зорилтын хүрээнд хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

1. “Халамжаас хөдөлмөрт” бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд Нийгмийн халамжийн тухай болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиудын шинэчилсэн найруулгыг боловсруулж байна. Хуулиудын шинэчлэлийн хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг зөв тодорхойлох, тэдгээр өрх, иргэдэд нийгмийн халамжийн дэмжлэгийг амьжиргаанд нь эергээр нөлөөлөхүйц хэмжээгээр олгох, харин нийгмийн халамж авч байгаа хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай хүнийг хөдөлмөр эрхлүүлэх замаар халамжаас хасахтай холбоотой үйлчилгээ, арга хэмжээг тусгана.

Түүнчлэн Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасны дагуу дотоодын хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх, ажлын байрыг хамгаалах, дотоодын ажиллах хүчийг мэргэшүүлэх зарчмыг тусгаж, хуулийн төслийг боловсруулаад байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд өөрчлөлт оруулан баталж, хуулийг иргэд, олон нийтэд

сурталчлан таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөгөөний дагуу улсын хэмжээнд зохион байгуулж байна.

2. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тасралтгүй хийж, хөдөлмөрийн статистик мэдээллийг боловсронгуй болгох, улмаар хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загварыг салбарын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэн, хөдөлмөрийн зах зээлийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагааны зохицуулалтад ашиглахаар төлөвлөж байна. Үүний үр дүнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг их өгөгдөл ашиглан оновчтой удирдах боломж бүрдэнэ.

3. Иргэд, олон нийтэд, ялангуяа хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ажил, мэргэжлээ сонгох гэж байгаа залуучуудад мэдлэг, мэдээллийг хүргэх, зөвлөн туслах ажилд тусгайлан анхаарал хандуулж ажиллана. Энэ хүрээнд шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, ирээдүйд эрэлт нь нэмэгдэх болон буурах ажил мэргэжил болоод ажиллах хүчинд гарах өөрчлөлт, салбар бүрд шинээр нэвтрэх технологи, ажил, мэргэжилд шаардагдах ур чадварууд зэрэг мэдээллийг судалгаа хийсний үндсэн дээр иргэд, олон нийт, залуучуудад мэдээлэх, улмаар зөв мэргэжил, зөв ажил сонгоход нь дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлогт нийцсэн байдлаар боловсронгуй болгож, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн шинэ төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Цар тахлын нөхцөл байдлын улмаас сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хязгаарлалтад орсонтой холбоотойгоор эмэгтэйчүүд гэртээ хүүхдээ харах шалтгаанаар ажиллах хүчнээс гадуур үлдэж байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс 16.7 хувиар бага байгаа тул эмэгтэйчүүдийн зайнаас ажиллах, хүүхэд харах үйлчилгээг сайжруулахад чиглэсэн шинэ төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр холбогдох тооцоо, судалгааг хийж байна.

5. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тэр дундаа албан бус эдийн засгийн салбарт ажиллагчдын дата, мэдээллийг нарийвчлан тодорхойлж, тэднийг албан эдийн засгийн салбарт шилжихийг дэмжсэн арга хэмжээг зохион байгуулна. Энэ хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)-тай хамтран "Албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа-2021"-г хийсэн бөгөөд энэхүү судалгааны тайлан, мэдээнд тулгуурлан эдийн засгийн хямралын үед ажлын байрыг хадгалах, хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлыг нийгмийн түншлэлийн болон бусад мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна.

6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд орон нутгийн захиргааны байгууллагуудын оролцоог хангаж, тухайн орон нутгийн онцлогт нийцсэн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд тодорхой тоон зорилтыг аймаг, нийслэл, дүүрэг бүрд дэвшүүлж, салбар дундын зохицуулалт, уялдааг хангах байдлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэр гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийн орлогоос шууд хамааралтай байгааг өөрчилж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулна.

Дэлхий нийтээр коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эсрэг тэмцэж, эдийн засаг, нийгмийн хүнд нөхцөл байдал, сорилтуудтай тулгарч байгаа хэдий ч Монгол Улсын Засгийн газар иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, ажлын байрыг хамгаалж ажил эрхлэлтийг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр шуурхай арга хэмжээ авч ажиллаж байна.

Цаашид ажилгүйдэл, ядуурлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүс, орон нутгийн эдийн засгийн бүтэц, онцлог, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, томоохон бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн чадавхтай ажиллах хүчний нөөцийг баялаг бүтээх үйлсэд татан оролцуулах, зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцсэн хөдөлмөрийн хэлбэр, хөдөлмөрийн үнэлгээ, хөдөлмөрийн харилцааг дэмжих замаар 3 жилийн дотор 150.0 мянган ажлын байр шинээр бий болгох, ядуу өрхийн 20.0 хувийг ядуурлаас гаргаж, тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарах болно.

Эдгээр зорилтыг ажил хэрэг болгож, бодит үр дүнд хүрэхэд хувийн хэвшил, бизнес эрхлэгчдийн уйгагүй хөдөлмөр, хичээл зүтгэл, төр, хувийн хэвшлийн түншлэл, үр ашигтай хамтын ажиллагаа нэн чухал байна.

-----oOo-----

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Ажиллах хүчний мэдээлэл

Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд¹, 2020 оны II улирлын байдлаар 15, түүнээс дээш насны 2123.9 мянган хүн ам байгаагаас 1207.0 мянга (56.8%) нь ажиллах хүч, 917.0 мянга (43.2%) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 61.9 (4.9%) мянгаар буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 62.4 (7.3%) мянгаар өссөн байна.

Нийт ажиллах хүчний 659.9 мянга (52.7%) нь эрэгтэйчүүд, 590.7 мянга (47.3) нь эмэгтэйчүүд байна. Мөн нийт ажиллах хүчний 1105.7 мянга (91.6 хувь) нь ажиллагчид, 101.3 мянга (8.4 хувь) нь ажилгүйдлийн хүч байна.

Улсын хэмжээнд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар ажилгүй хүн 101.3 мянга байгаагийн 52.9 (52.3%) мянга нь эрэгтэйчүүд, 48.4 (47.7%) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 17.6 (21.0%) мянга, өмнөх улирлаас 0.1 (0.1%) мянгаар өссөн байна.

Хүснэгт 1: Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021-2 улирал
Монгол Улсын нийт хүн ам (мян.хүн)	2930.2	2995.9	3057.7	3119.9	3177.8	3238.5	3296.8	3357.5	-
15 ба түүнээс дээш насны хүн ам (мян.хүн)	1937.1	1941.5	2022.9	2107.0	2220.4	2173.0	2105.9	2128.1	2123.9
Ажиллах хүч (мян.хүн)	1198.3	1206.5	1243.8	1275.6	1357.4	1358.6	1273.9	1250.6	1207.0
Ажиллагчид (мян.хүн)	1103.6	1110.7	1151.2	1147.8	1238.3	1253.0	1146.2	1162.9	1105.7
Ажилгүй иргэд (мян.хүн)	94.7	95.8	92.6	127.8	119.1	105.6	127.7	87.7	101.2
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам (мян.хүн)	738.7	734.9	779.0	831.3	863.0	868.0	832.2	877.5	916.9
Ажиллах хүчний оролцооны түвшин (%)	61.9	62.1	61.5	60.5	61.1	61	60.5	57	56.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (%)	57	57.2	56.9	54.5	55.8	56.3	54.4	54.6	52.1
Ажилгүйдлийн түвшин (%)	7.9	7.9	7.5	10.0	8.8	7.8	10	7.0	8.4

Ажилгүйдлийн түвшин 2021 оны II улирлын байдлаар улсын хэмжээнд 8.4 хувь байгаа бөгөөд үүнийг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 8.2 хувь, эмэгтэйчүүдийнх 8.6 хувь байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 9.7 хувь буюу улсын дунджаас 1.3 дээгүүр, харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин 5.6 хувь байгаа нь улсын дунджаас 2.8 нэгж хувиар доогуур байна. Ажилгүйдлийн түвшинг бүсээр харахад, Баруун бүсэд 10.5 хувь байгаа нь улсын дунджаас 2.1 пунктээр дээгүүр байна. Ажилгүйдлийн түвшинг аймгаар авч үзэхэд Увс, Ховд, Говьсүмбэр, Говь-Алтай, Орхон, Баянхонгор, Дархан-Уул, Баян-Өлгий, Сэлэнгэ аймагт улсын дунджаас 0.2-14.9 нэгж хувиар дээгүүр байна

¹ www.1212.mn

Ажиллагчид ²

2021 оны II улирлын байдлаар ажиллагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80 гаруй мянгаар буюу 6.7 хувиар буурсан бөгөөд уг бууралтыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь харвал салбар бүрт харилцан адилгүй байв. Ажиллагчдын хамгийн их өсөлт нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (21.4 мянга), зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (11.3 мянга), цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж (7.0 мянга) зэрэг салбарууд байсан бол бууралт нь хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа (24.8 мянга), бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ (23.0 мянга), боловсрол (17.3 мянга)-ын салбарт гарсан байна.

Хүснэгт 2: ³Ажиллагчдын тооны өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Хүснэгт 3: Ажиллагчид /Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар 2015 оноос хойш/ мянган хүн

№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2015	2016	2017	2018	2019	2020	2021 -2 улирал
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	327.5	348.8	356.4	334.1	290.1	276.4	290.6
2	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	178.2	172.7	204.5	211.2	160.4	166.5	152.5
3	Боловсрол	89.0	95.0	98.9	98.7	96.1	110.7	93.2
4	Боловсруулах үйлдвэрлэл	81.3	86.1	93.0	100.8	90.3	89.7	87.7
5	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	68	74.2	82.2	76.2	86.0	83.3	83.1
6	Барилга	88.1	71.5	70.6	76.5	68.8	77.2	85.5
7	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	72.7	66.0	72.7	73.6	61.1	66.5	50.7
8	Уул уурхай, олборлолт	42.6	38.2	52.0	57.7	57.9	51.5	57.4
9	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	38.2	41.0	40.0	49.5	44.3	60.1	41.6
10	Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	38.0	32.1	36.4	37.5	36.2	29.9	40.2
11	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	20.2	19.8	22.7	23.4	24.5	29.7	23.2
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	24.0	21.8	24.1	25.7	24.2	29.3	24.4
13	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	16.0	15.0	20.8	18.2	20.1	18.0	15.6
14	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	15.6	16.1	17.5	16.3	19.3	14.3	19.4
15	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	14.1	12.6	12.7	14.6	18.0	11.6	6.0
16	Урлаг, үзвэр, тоглоом наадам	12.3	10	10.1	13.8	17.9	10.8	9.0

² www.1212.mn

³ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт


17	Мэдээлэл, холбоо	16.0	18.1	14.5	14.0	13.0	18.8	16.9
18	Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5.9	6.0	4.9	6.9	10.7	8.3	6.8
19	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.9	1.0	2.3	1.2	3.2	3.2	0.6
20	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.7	1.1	1.5	2.3	2.0	2.6	-
21	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.9	0.7	0.4	0.8	1.1	3.4	1.7
	Улсын дүн /мян.хүн/	1151.2	1147.8	1238.3	1253.0	1146.2	1162.9	1105.7

Ажилгүй хүн⁴

Ажилгүйчүүдийг бүсээр авч үзвэл 18.9 хувь нь Баруун бүс, 14.4 хувь нь Хангайн бүс, 17.4 хувь нь Төвийн бүс, 4.3 хувь нь Зүүн бүс, 45.0 хувь нь Улаанбаатар хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал Баруун бүс 6.2 мянгаар, Төвийн бүс 5.6 мянгаар, Улаанбаатар 3.5 мянгаар, Хангайн бүс 2.4 мянгаар өссөн бол Зүүн бүс 0.3 мянгаар буурсан байна.

Мөн ажилгүйчүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл 3.8 мянга (3.8 хувь) нь 15-19 насны, 33.3 мянга (32.9 хувь) нь 20-29 насны, 26.7 мянга (26.4 хувь) нь 30-39 насны, 25.1 мянга (24.8 хувь) нь 40-49 насны, 11.5 мянга (11.4 хувь) нь 50-59 насны, 0.7 мянга (0.7 хувь) нь 60, түүнээс дээш насны хүн байна.

Хүснэгт: 4 Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, улирлаар, мянган хүн



⁴ www.1212.mn,

Хөдөлмөрийн зах зээлийн тойм, 2021 оны 2 дугаар улирал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭ¹

Хүснэгт 5 /мянеан хүн/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021.09 сар
Ажил хайгч иргэний тоо	-	-	52311	47618	46795	37074	36169	37044	29952	21804
Ажлын байрны захиалгын тоо (оны эцэст өссөн дүнгээр)	104056	219013	114377	77699	57930	62574	64478	71124	58022	32656
Ажилд зуучлагдсан иргэний тоо (тайлант хугацааны эцэст өссөн дүнгээр)	34799	65632	54367	49739	35846	45683	43105	44059	33006	17636
Ажилд зуучлалын гүйцэтгэл (АЗ/АБЗ харьцаа %-иар)	33.4	30	47.5	64	72.1	73	67	62	56.8	54
Шинэ ажлын байранд орсон иргэний тоо (өссөн дүнгээр)	54695	59816	55909	50725	34520	27284	27146	33325	31800	14341
Бүртгэлтэй ажилгүй иргэний тоо /тухайн тайлант хугацааны эцэст/	35776	42772	36970	32788	34412	25450	24964	20761	18103	15053
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл авсан хүний тоо	-	-	-	47992	54533	105113	111877	96668	51567	24182
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр. арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	132509	112069	56607	83232	33716	64875	65715	74487	29127	14918
Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо	10617	15859	16600	18700	23100	21200	21423	23033	21386	19263 /9 сар/
Ажилгүйдлийн тэтгэмжийн хөрөнгө (сая.төг)	7308.3	14930	17800	22300	31600	34700	34300	43005	50226	39.4 тэрбум /9 сар/
Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээ авсан иргэний тоо /оны эхнээс өссөн дүнгээр/	-	-	114548	79447	53271	51890	50136	47421	16372	15509
Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо	10060	8863	7971	6779	5938	4703	4502	4601	5058	5741
Гадаадад ажиллах хүч илгээх үйлчилгээ авсан иргэний тоо	-	-	64600	41072	22464	36574	58078	92517	30498	34797
БНСУ-д илгээсэн Монгол иргэний тоо	2781	2153	1542	1113	944	1058	784	784	63	22
Япон Улсад ажиллахаар хил нэвтэрсэн иргэдийн тоо									12	-
	/2018 оноос эхлэн хэрэгжиж байна/									

¹ Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар

² ХНХЯ-ны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД ³

Хүснэгт 6

№	Хөтөлбөрийн нэр	Хамрагдсан хүн	Үүнээс эмэгтэй	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Бий болсон ажлын байр	Үүнээс:		
						Байнгын	Түр	Цагийн
1	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	8590	4084	6,233,567.2	5418	1584	3834	
2	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	531	381	925,181.0	596	397	199	
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	1420	672	2,921,445.8	643	643		
4	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	1897	1097	124,750.6	94	94		
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	2378	1271	160,480.1	1810	45		1765
6	Хүүхэд хамгаалагч төсөл	102	22	68,201.0	102	102		
	Нийт	14918	7527	10,433,625.7	8663	2865	4033	1765

2021 оны 09 дүгээр сарын байдлаар

³ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар